



МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 10-14

Улаанбаатар хот

Г

1

ИНКУБАТОРТ ЦАХИМ /ONLINE/-р КОМПАНИ, БАГ, ИРГЭНИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛЖ ЭЛСҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ АЖЛЫН ХЭСЭГ
БАЙГУУЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, 20.1.11, Мэдээллийн технологийн үндэсний паркын дүрмийн 6.6.7 дахь хэсгийн заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

НЭГ. Мэдээлэл, технологийн үндэсний паркын инкубаторт цахим /online/-р компани, баг, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулах журмыг хавсралт ёсоор БАТАЛСУГАЙ.

ХОЁР. Мэдээлэл, технологийн үндэсний паркын инкубаторт цахим /online/-р компани, баг, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулах журмыг 2020 оны 04 дугаар сарын 20-с эхлэн дагаж мөрдөн ажиллахыг ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.

ГУРАВ. Мэдээлэл, технологийн үндэсний паркын инкубаторт цахим /online/-р компани, баг, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулах журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төслийн удирдлага, сургалт, маркетингийн хэлтсийн дарга /П.Наранцэцэг/-т ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.

ЗАХИРАЛ



Э.ЦОГТГЭРЭЛ



**ИНКУБАТОРТ ЦАХИМ /ONLINE/-Р КОМПАНИ, БАГ, ИРГЭНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛЖ
ЭЛСҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ
АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Мэдээллийн технологийн үндэсний паркын /цаашид МТҮП гэх/ инкубаторт онлайнаар компани, баг, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх ажлыг зохион байгуулах, инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үүрэг бүхий орон тооны бус шалгаруулалтын зөвлөл /цаашид Шалгаруулалтын зөвлөл гэх/-ийг байгуулах, сонгон шалгаруулалтын болон үнэлгээний ажлын хэсгүүдийг томилж ажиллуулах, тэдний гүйцэтгэх ажил үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2 Мэдээллийн технологийн инкубаторын үйл ажиллагааны журам, ахисан түвшний журам, оюутан бизнес инкубаторын үйл ажиллагааны журам, виртуал инкубатор, мэдээллийн технологийн инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх журам, холбогдох дүрэм нь энэхүү журмын салшгүй хэсэг байна.

1.3 Цахим элсэлт, үйл ажиллагаанд нь хяналт хийж, үнэлгээ өгөх/ цаашид үнэлгээ гэх/ зохион байгуулах явцад ажлын хэсгийн үйл ажиллагааг МТҮП-ын холбогдох нэгжийн мэргэжилтэн /цаашид менежер гэх/ удирдан зохион байгуулна

1.4. Онлайн элсэлт, үнэлгээ зохион байгуулах үед ажлын хэсгийг томилоходоо МТҮП-ын холбогдох журмыг мөрдлөг болгоно

1.5. Шалгаруулалт болон үнэлгээний ажлын хэсгийг гишүүдийн бүрэлдэхүүнд олон улсад /нэр хүндтэй / ажиллаж буй Монгол улсын иргэн байж болно

1.6. Цахим элсэлт, үнэлгээний нэгдсэн дүнг ажлын хэсгийн гишүүдээр заавал 1-3 хоногийн дотор багтаан баталгаажуулах ба гадаадад байгаа бол үнэлгээний хуудсанд гарын үсгээ зурж /PDF/ өргөтгөл болгон буцаан илгээнэ

1.7. Энэхүү журмын биелэлтэнд МТҮП хяналт тавьж ажиллана.

Хоёр. Нэр томъёо

2.1 Шалгаруулалтын зөвлөл: Инкубаторт иргэн, компанийг сонгон шалгаруулж элсүүлэх, инкубаторын компаниудад хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг гүйцэтгэх чадамж бүхий тухайн салбартаа мэргэшсэн, гадаадад болон дотоодын мэргэжилтэн, шинжээчдээс бүрдэх орон тооны бус шалгаруулалтын зөвлөл;

2.2 Сонгон шалгаруулах ажлын хэсэг: Инкубаторт компани, баг, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх үүрэг бүхий Шалгаруулалтын зөвлөлийн гишүүдээс сонгож байгуулах ажлын хэсэг;

2.3 Үнэлгээний ажлын хэсэг: Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үүрэг бүхий Шалгаруулалтын зөвлөлийн гишүүдээс сонгож байгуулах ажлын хэсэг;

2.4 Нууцлалын гэрээ: МТҮП-аас дээрх 2 ажлын хэсгийн гишүүнтэй инкубаторын компаниудын бизнес, санхүүгийн мэдээллийн нууцлалыг чандлан сахих талаар байгуулах гэрээ;

2.4.1 Нууцлалын гэрээг байгуулахдаа МТҮП-с боловсруулсан гэрээний дагуу гарын үсгийн баталгаажуулалтыг хийн холбогдох ажилтанд зураг хэлбэрээр /JPEG/ ирүүлнэ.

2.5 Зорилтот салбар: Нэг буюу хэд хэдэн салбарын хэмжээнд тодорхой сэдвээр зарлах төсөл хөтөлбөрт оролцуулах, инновацийг дэмжих зорилгоор МТҮП-аас зорилтот хэмээн тухайлан чиглэл болгож зарлах салбар.

2.6 Менежер: Онлайн элсэлт, үнэлгээ зохион байгуулахад элсэгч болон үнэлгээнд орж буй компани, иргэн, баг, ажлын хэсгийн гишүүдийг холбох, хугацааг хянах, дүнг нэгтгэн танилцуулах үүрэг бүхий мэргэжилтэн /зөвхөн МТҮП-ын мэргэжилтэн байна./

2.7 Баталгаажуулалт гэдэг нь “танилцсан” болон “хүлээн авлаа” гэсэн цахим шуудангийн хариу илгээхийг хэлнэ.

2.8 Хувийн дугаар гэдэг нь үнэлгээний хуудас нь дээр байгаа 1-7 хүртэл тоог хэлнэ.)

2.9 Улирал тутмын үнэлгээ гэж сар бүрийн үнэлгээний дунджыг хэлнэ.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1 Инкубаторт компани, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх, инкубаторын компаниудад хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий 25-30 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус шалгаруулалтын зөвлөлийг МТҮП-ын захирлын шийдвэрээр байгуулна.

3.2 Шалгаруулалтын зөвлөл нь тухайн салбартаяа тэргүүлэх зэргийн мэргэжилтнүүдээс бүрдэнэ.

3.3 Шалгаруулалтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шаардлагатай тохиолдолд МТҮП-ын захирлын шийдвэрээр байнгын нэмэлт шинэчлэлт хийнэ.

3.4 Шалгаруулалтын зөвлөлөөс инкубаторт компани, баг, иргэнийг сонгон шалгаруулж, элсүүлэх ажлын хэсэг /цаашид сонгон шалгаруулах ажлын хэсэг гэх/ болон инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсэг /цаашид үнэлгээний ажлын хэсэг гэх/-ийг МТҮП-ын захирлын шийдвэрээр тухай бүр томилон ажиллуулна.

3.5 Шалгаруулалтын зөвлөлөөс дээрх 2 ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг сонгохдоо аль болох бүх гишүүдийг ээлжлэн хамруулах, нэг гишүүнийг олон дахин дараалж, давхардуулан сонгохгүй байх зарчим баримтална. Сонгон шалгаруулах ажлын хэсэгт нэг гишүүнийг дараалан 3 болон түүнээс дээш удаа давтан сонгохгүй. Энэ нь МТҮП-ын ажилтан, албан хаагчдад хамаарахгүй

3.6 Сонгон шалгаруулалт болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө шалгаруулалтын зөвлөлөөс 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр МТҮП-ын захирлын шийдвэрээр сонгон шалгаруулах ажлын хэсгийг томилж ажиллуулна.

3.6.1 Зорилтот салбарын чиглэлээр сонгон шалгаруулалт зарласан тохиолдолд 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж болно

3.7 Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө Шалгаруулалтын зөвлөлөөс 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр МТҮП-ын захирлын шийдвэрээр үнэлгээний ажлын хэсгийг томилж ажиллуулна.

Дөрөв. Шалгаруулалтын зөвлөл

4.1 Шалгаруулалтын зөвлөлийг бүрдүүлэх

4.1.1 Шалгаруулалтын зөвлөлийн гишүүдийг МТҮП-ын инкубаторын үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий албан тушаалтан, МТҮП-ын захирал, холбогдох албан тушаалтнаас санал авсны үндсэн дээр байгуулна.

4.1.2 Шалгаруулалтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг МТҮП-ын захирлын тушаалаар батална.

4.1.3 Шалгаруулалтын зөвлөл нь мэдээллийн технологийн салбарын төрийн байгууллага, мэргэжлийн их дээд сургууль, бизнесийн байгууллага, олон улсад амжилттай яваа салбарын мэргэжилтнүүд, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, хөрөнгө оруулагчдын төлөөллөөс бүрдэнэ.

4.2 Шалгаруулалтын зөвлөлийн гишүүдэд тавигдах ерөнхий шаардлага, баримтлах зарчим

4.2.1. Мэдээллийн технологийн салбарт инноваци хийх, шинэ санааг бүтээгдэхүүн болгох чиглэлээр мэдлэг, туршлага бүхий байна.

4.2.2. Компаниудын бизнес төлөвлөгөө, шинэ санааны төсөлд үнэлэлт дүгнэлт өгөх чадамжтай байна.

4.2.3. Компаниудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхдөө үнэн зөв, шударга, хараат бус, зарчимч байр сууринеас хандаж ажиллана.

4.2.4. Шалгаруулалтын зөвлөлийн гишүүд нь ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

Тав. Инкубаторт компани, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх ажлын хэсэг байгуулах

5.1 Инкубаторт компани, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх ажлыг МТҮП-н өрөө танхимиийн нөөц бололцоонос хамаарч тухай бүр зохион байгуулна.

5.2 Инкубаторт компани, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүдийн 4-өөс доошгүй нь мэдээллийн технологийн мэргэшсэн мэргэжилтэн байна. Сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүдийг дараах төлөөлөлтэй байхаар МТҮП-ын захирал Шалгаруулалтын зөвлөлөөс тухай бүр томилж ажиллуулна.

Үүнд : 5.2.1. Харилцаа, холбоо, мэдээлэл технологийн газрын (ХХМТГ) төлөөлөл - 1;

5.2.2. МТҮП-ын төлөөлөл - 2;

5.2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн дотоод болон гадаадад ажиллаж буй мэргэжилтнүүдийн төлөөлөл- 2;

5.2.4. Мэдээллийн технологийн чиглэлийн бизнесийн шинжээч - 1;

5.2.5. Хөрөнгө оруулагчийн төлөөлөл – 1;

5.2.6. Зорилтот салбарын чиглэлээр сонгон шалгаруулалт зарласан тохиолдолд тухайн салбар байгууллагын буюу санхүүжүүлэгч байгууллагын төлөөлөл-2

5.3 Сонгон шалгаруулах ажлын хэсгийн ахлагч нь МТҮП-ын захирал байна. Төлөөлүүлж МТҮП-ын холбогдох албан тушаалтныг томилон ажиллуулж болно.

Зургаа. Сонгон шалгаруулалтын дүнг гаргах

6.1 Сонгон шалгаруулалтыг “Мэдээллийн технологийн инкубаторын үйл ажиллагааны журам”-ын дагуу зохион байгуулна.

6.2 Сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн гишүүд “Мэдээллийн технологийн инкубаторын үйл ажиллагааны журам”-ын 4.1-д заасан элсэлтийн шалгуур үзүүлэлт нэг бүрт өөрсдийн үнэлгээ /0-5 оноо/-г өгнө.

6.3 Ажлыг хэсгийн гишүүд үнэлгээг өгсөний дараа 10 минутын дотор үнэлгээний хуудсыг баталгаажуулалт хийгдсэн цахим шуудангаар (PDF) болгон илгээнэ. /10 минутаас хоцорвол үнэлгээний дүнг хүчингүй тооцно./

6.4 Ажлын хэсэг хүсэлт гаргагч нэг бүрээр шалгаруулалтын дүнг жагсааж, авсан онооны дарааллаар байр эзлүүлнэ. Оноо тэнцсэн тохиолдолд шалгуур үзүүлэлт тус бүрээр авбал зохих онооны 80-аас доошгүй хувийг хангасан эсэхээр нь харьцуулж үзнэ. Бүх үзүүлэлтээрээ тэнцсэн тохиолдолд сонгон шалгаруулалтын ажлын хэсэг дахин санал хурааж, байр эзлүүлнэ./

6.5 Ерөнхий үнэлгээгээр авбал зохих нийт онооны 80-аас доошгүй хувийн үзүүлэлттэй байвал тухайн хүсэлт гаргагчийг инкубаторт элсүүлэх боломжтой гэж үзнэ.

Долоо. Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулах

7.1 Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг улирал, хагас жил, жил тутам зохион байгуулна.

7.2 Улирал тутмын үнэлгээг холбогдох нэгж хэлтэс, алба, төв, газар гүйцэтгэх бөгөөд үнэлгээний нэгдсэн дүнг МТҮП-ын захиралд танилцуулан гэрээг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлүүлнэ.

7.3 Инкубаторын компаниудын хагас жил, жил тутмын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсгийн гишүүдийг Шалгаруулалтын зөвлөлөөс МТҮП-ын захирал дараах төлөөлөлтэй байхаар тухай бүр томилж ажиллуулна. Үүнд

7.3.1 ХХМТГ-ын төлөөлөл- 1;

7.3.2 МТҮП-ын төлөөлөл – 2;

7.3.3 Мэдээллийн технологийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийг дотоод болон гадаадад ажиллаж буй мэргэжилтнүүдийн төлөөлөл-1;

7.3.4 Мэдээллийн технологийн чиглэлийн бизнесийн шинжээч – 1.

7.3. Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хагас жил, жил тутамд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг “Мэдээллийн технологийн инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх журам”-ын дагуу зохион байгуулна

Найм. МТҮП-ын эрх, үүрэг

8.1 МТҮП нь ажлын хэсгийн гишүүдийн үнэлэлт дүгнэлт өгч байгаа байдал, ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавина.

8.2 Ёс зүйн алдаа гаргасан гишүүнийг МТҮП-ын захирлын шийдвэрийн үндсэн дээр шалгаруулалтын зөвлөлөөс хасна.

8.3 МТҮП-ын тухайн цаг үед ашиглаж буй /Hangout болон бусад/ программын дагуу онлайн элсэлтийг явуулна

8.4 Элсэлт болон үнэлгээний материалыг бэлтгэн ажлын хэсгийн гишүүдэд 1 өдрийн өмнө өгч танилцуулсан байна. /Үнэлгээний хуудас, холбогдох дүрэм журам, танилцуулга байна/

8.5 Менежер эхлэх цагийг гишүүдэд анхааруулсаны дараа элсэхийг хүсэгч компани, баг, иргэн болон хагас жил тутмын үнэлгээнд орж буй компаниуд танилцуулга эхлүүлэх зөвшөөрөл өгнө. /Хугацаа 15 мин/

8.6 Менежер дарааллын дагуу асуултыг авах зохион байгуулалт хийнэ.

8.7 Инкубатор цахим элсэлт болон үнэлгээ нэгтгэсэн дүнг ажлын хэсгийн гишүүд дүнгээ явуулсанаас хойш 10 минутын дараа шүүгчдэд илгээж баталгаажуулна.

8.8 МТҮП нь ажлын хэсгийн гишүүдэд ажил үүргээ саадгүй гүйцэтгэх орчин нөхцлийг бүрдүүлж, өрөө танхим, техник хэрэгслээр хангана.

8.9 Инкубаторын сонгон шалгаруулалт, үнэлгээ зохион байгуулсан тухай болон инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн тухай мэдээллийг МТҮП-ын шалгаруулалтын зөвлөлд цаг тухайд нь өгч байх үүрэгтэй.

Ес. Ажлын хэсгийн гишүүдийн ажиллах зарчим, эрх, үүрэг

9.1 Инкубатор цахим элсэлт, үнэлгээ эхлэх цагт ажлын хэсгийн шүүгчид өөрсдийн компьютерыг асаан зааварчилгааг хүлээнэ.

9.2 Ажлын хэсгийн гишүүд нууцлалын гэрээтэй танилцсан эсэхээз баталгаажуулж хариу илгээнэ.

9.3 Элсэхийг хүсэгчид болон үнэлгээнд оролцож буй компани нь танилцуулгаа хийж дусмагц үнэлгээний хуудасны хувийн дугаараар асуулт асуух хүсэлтээ явуулаад өөрсдийн микрофонoo нээнэ.

9.4. Ажлын хэсгийн гишүүд асуулт болон санал байвал тухайн үйл ажиллагааг удирдаж буй менежерийн зааврын дагуу асуулт асууж, саналаа хэлнэ. Хугацаа 1-3 мин

9.5 Ажлыг хэсгийн гишүүд нэмэлт санал байхгүй бол менежерийн зааврын дагуу үнэлгээний дүн өгөх ажлыг гүйцэтгэнэ

9.6. Ажлын хэсэг үнэлгээ өгсөний дараа 10 минутын дотор үнэлгээний хуудсыг баталгаажуулан цахим шуудангаар (PDF) өргөтгөл болгон илгээнэ. /10 минутаас хоцорвол үнэлгээний дүнг хүчингүй тооцно./

9.7 Шалгаруулалтын зөвлөл, ажлын хэсгийн гишүүд нь инкубаторт хяналт шинжилгээ хийж үнэлгээ өгөх журам болон инкубаторын компаниудын бизнесийн шинэ санаа, технологи, бизнес төлөвлөгөө, санхүүгийн мэдээллийн нууцлалыг чандлан сахих үүрэг хүлээнэ.

9.8 Ажлын хэсэг нь компаниудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхдөө үнэн зөв, шударга, зарчимч байр сууринаас хандана.

9.9. Шалгаруулалтын зөвлөлийн гишүүн нь ажлын хэсэг болон зөвлөлийн гишүүнээс сайн дураараа татгалзаж болно.

Арав. Ажлын хэсгийн гишүүдийн хориглох зүйл

10.1 Ажил, албан тушаалын онцлогоос хамааран инкубаторт элсэхийг хүсэгчдийн болон инкубаторын компаниудын бизнесийн санаа, санхүүгийн нууцыг задруулах, албан тушаалдаа урвуулан ашиглах, эрх мэдлээ хэтрүүлэхийг хориглоно.

10.2 МТҮП-ын удирдлага, холбогдох ажилтнууд, Шалгаруулалтын зөвлөлийн бусад гишүүдэд шууд ба шууд бус аргаар нөлөөлөх, ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад хийхийг хориглоно.

10.3 Танилцуулах явцад ажлын хэсгийн гишүүд ямар нэг асуулт асуух, дуу чимээ гаргахыг хориглоно.

Арван нэг. Ажлын хэсгийн гишүүний урамшуулал

11.1 Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан шалгаруулалтын зөвлөлийн шүүгчидэд урамшуулал олгоно. Урамшууллын хэмжээг гүйцэтгэх ажлын хэмжээтэй нь уялдуулан МТҮП-ын захирал тогтооно.

11.2 Ажлын хэсгийн гишүүдийн урамшууллыг олгоходоо Хүн амын орлогын албан татварын тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуульд заасан холбогдох шимтгэл суутгалыг хасч тооцно.